


ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗАР 11 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН ТАЙЛАН

Барилга, хот байгуулалтын хэлтэс

Барилга захиалагчийн хяналтаар:

2023 оны 4-р улирлын байдлаар хөрөнгө оруулалтын ажлуудын ажлын гүйцэтгэл ажлын явцын тайлан

Орон нутгийн өмчит байгууллагуудын их засварын ажил: Баянталд хийгдэх 4-р сургуулийн спорт заалны дээврийн засварын ажлыг бүрэн хийж дууссан. Байгаль орчны газарт хийх ажлын шал, хана таазны эмульс замаскийн ажил болон ариун цэврийн өрөөний засварын ажил хийгдсэн байна. АЗДТГ-ын засварын ажил ханын тэгшилгээ замаск, таазны ажил хийгдсэн. Татварын байрны засварын ажил хана таазны тэгшилгээ хийгдсэн. Барилгын ажлын гүйцэтгэл 70 хувьтай үргэлжилж байна.




Говьсүмбэр аймгийн халуун усны барилгын ажил: Барилгын ажлын дотор хананы өрлөгийн ажил дууссан. Дотор ханын шавардлагын ажил болон Гадна цэвэр ус татах ажил, цахилгааны ажлууд хийгдэж байна. Барилгын ажил 80 хувьтай явагдаж байна.



Аймгийн төвийн 2,8км авто замын ажил: Авто замын ажлын гүйцэтгэл 95 хувьтай босоо тэмдэг тэмдэглэгээ замын хөвөө цэвэрлэх ажил хийгдэж байна. Улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажил хийгдэж байна.



Худалдаачны гудамжны тохижилт: Дугуйн замын асфальт хучилт хийгдсэн. Гэрэлтүүлгийн ажлууд хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 80 хувьтай



0,36км автозамын ажил: Авто замын ажлын гүйцэтгэл 95 хувьтай. Улсын комисст хүлээлгэн өгөх бэлтгэл ажил хийгдэж байна.





Боржигон чуулгын барилга: Барилгын ажлын гүйцэтгэл нийт гүйцэтгэл 60 хувьтай. Барилгын талбайд дотор хана шаврын ажил хийгдэж байна. Гадна фасадын материал барилгын ажлын талбайд буусан байна.






Газрын удирдлагын хэлтэс

Аймгийн хэмжээний 10 багийн заагийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн 2023 оны 07 дугаар тогтоолоор батлуулан газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газарт хүргүүлэн ажилласан.



Мөн аймгийн хэмжээний тэг гортиг болон газрын нэгдмэл сангийн ангилал хооронд шилжүүлэх асуудлыг сумдын Засаг дарга нараас санал авч аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн барьж хэлэлцүүлэхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.



Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 105 дугаар тогтоолын дагуу 2023 оны 11 дүгээр сарын 20-21-ний өдрүүдийн хооронд Баянтал суманд 5 байршилд 58 иргэний өмчлөлийн материалыг авах ажлыг Баянтал сумын Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан боловч 2023 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар 52 иргэний материалыг хүлээн аваад байна.



Аймгийн хэмжээнд мэргэжлийн эрх бүхий тусгай зөвшөөрөлтэй 1 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд тус аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд 2023 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр хяналт шалгалтыг хийн ажилласан.



Сумдын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүдэд мэргэжил арга зүйгээр хангах, хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах, туршлага судлуулах, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Сумдын Газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн гишүүд, Сумдын Иргэдийн төлөөлөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга нар Багийн Иргэдийн нийтийн хурлын дарга нарт 2023 оны 11 дүгээр сарын 02-ний өдөр сургалт зохион байгуулан ажилласан.



Газрын удирдлагын хэлтсийн шинэ албан хаагчдыг чадавхжуулах сургалт болов. Сургалтын зорилго нь шинээр ажилд орсон албан хаагчдын ажиллах ур чадварыг дээшлүүлэх, сайжруулах, мэргэжил арга зүйг хангах, Газрын удирдлагын цахим систем программ хангамжийн хөгжүүлэлт, мэдээ тайланг чанартай хугацаанд нь гаргах, хоорондын үйл ажилгааны уялдаа холбоог сайжруулах туршлага судлуулах, ур чадварыг дээшлүүлэх зорилготой сургалтын зохион байгуулсан.



Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн А/326 дугаар захирамжийг үндэслэн газар, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний 2 байршилд дуудлага худалдааг цахимаар зохион байгуулахаар зарлаж Зарыг Зууны мэдээ сонин, байгууллагын сайт, газрын биржийн цахим системд байршуулав. Тухайн дуудлага худалдаа 2023-12-14 цагт цахимаар зохион байгуулагдана.

The screenshot displays the Mongolian Real Estate Auction System website. The main header includes navigation links: НҮҮР, ДУУДАГА ХУДАЛДАА, ТӨСӨЛ ШАЛГАРУУЛАЛТ, ХУДАЛДАА/ТҮРЭЭС, ҮНИЙН МЭДЭЭ, ГАЗРЫН ЗУРАГ. The left sidebar contains filters for location (ОН: 2023, ЗАРЫН КОД: 42021, ГАЗРЫН ТӨРӨЛ: Бүгд), status (Төлөв: Оролцогчдыг бүртгэж буй, Төлөөлөгдөж буй, ДХ явагдаж буй, ДХ дууссан), and region (БАЙРШИЛ: АЙМАГ/НИЙСЛЭЛ: Говьсүмбэр, СУМ/ДҮҮРЭГ: Сүмбэр, БАГ/ХИРӨӨ).

The main content area shows a list of properties for sale. Two properties are highlighted:

- ГОВЬСҮМБЭР СУМБЭР 1-Р БАГ**: Худалдаа, нийтийн төсөлөгчдийн газар, ...
94,500 ₮, 21 м², 2023-12-14
- ГОВЬСҮМБЭР СУМБЭР 2-Р БАГ**: Худалдаа, нийтийн төсөлөгчдийн газар, ...
558,000 ₮, 124 м², 2023-12-14

The bottom section contains links to БИДНИЙ ТУХАЙ, БУСАД МЭДЭЭЛЭЛ, ХАРИЛЦАХ ХАЯГ, and ГАР УТАСНЫ ПРОГРАМ. The system time is 14:47:25.